

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НЭГЖИЙН АЖИЛТНЫ  
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

**Хэрэгжүүлэгч байгууллага:** Эрүүл мэндийн яам

Эрүүл мэндийн яам нь Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид ажиллах дараах ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаж байна. Үүнд:

- 1)Төслийн дэд зохицуулагч, 2) Барилгын инженер, 3) Санхүүгийн ажилтан
- 4) Жолооч

**ӨРГӨДӨЛ ИРҮҮЛЭХ ХУГАЦАА, БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

Ажилд орохыг сонирхогчид дараах материалыг **2026 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 14:00** цагаас өмнө (Монгол, Англи хэл дээр) дор дурдсан хаягаар мэйл хаягаар ирүүлнэ.

1. Тухайн ажлын байранд томилогдох хүсэлт, өөрийн мэдлэг, ур чадвараа илэрхийлсэн өргөдөл (cover letter). Өргөдөл өгч буй ажлын байрны нэрийг тодорхой бичнэ.
2. Товч намтар (CV, цээж зурагтай).
3. Боловсрол, мэргэжил, ур чадварыг нотлон харуулах диплом, гэрчилгээний хуулбар.
4. Өмнөх ажил олгогчийн 2-с доошгүй ажил байдлын тодорхойлолт (reference letter).

Эрүүл мэндийн яам

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
1-р хороо, Засгийн газрын VIII байрны өргөтгөл  
3 давхарт 302 тоот

Утас: 329369

Цахим шуудангийн хаяг: [altantsetseg.batsukh@hsdp.org](mailto:altantsetseg.batsukh@hsdp.org);

ТӨСЛИЙН ДЭД ЗОХИЦУУЛАГЧИД  
ТАВИГДАХ ШААРДЛАГА:

А. Ерөнхий шаардлага:

- а. Дээд боловсролын магистраас доошгүй зэрэгтэй байх;
- б. Төрийн удирдлага болон эрүүл мэндийн бодлого, төлөвлөлтөөр их дээд сургууль төгссөн бол давуу тал болно.

В. Ажлын туршлага:

- а. Эрүүл мэндийн салбарт 10-оос доошгүй жил ажилласан туршлагатай, үүнээс 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан байх;
- б. Төрийн захиргааны байгууллагад ажиллаж байсан бол давуу тал болно.

С. Бусад

- а. Англи хэлний аман болон бичгийн түвшинд чөлөөтэй эзэмшсэн байх шаардлагатай;
- б. Олон Улсын 3-аас доошгүй төсөл хөтөлбөрт ажиллаж байсан туршлагатай байх;
- в. Албан бичиг, гүйцэтгэлийн тайлан хянах, бичиг баримт боловсруулах туршлага, ур чадвартай байх;
- г. Компьютерын өргөн хэрэглээний болон санхүүгийн программыг бүрэн эзэмшсэн байх;
- д. Багаар ажиллах чадвартай байх.

ТӨСЛИЙН БАРИЛГЫН ИНЖЕНЕРТ  
ТАВИГДАХ ШААРДЛАГА:

А. Ерөнхий шаардлага:

- а. Хамаарах чиглэлээр дээд боловсролын магистраас доошгүй зэрэгтэй байх;
- б. Архитектур, барилгын хийцлэлийн чиглэлээр мэргэшсэн байх;  
Мэргэжлийн зэрэгтэй байх.

В. Ажлын туршлага:

- а. Мэргэжлээрээ 10-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- б. Барилгын ажлын хяналт, албан бичиг, гүйцэтгэлийн тайлан хянах, бичиг баримт боловсруулах туршлага, ур чадвартай байх.

С. Бусад

- а. Англи хэлний аман болон бичгийн түвшинд чөлөөтэй эзэмшсэн байх шаардлагатай;
- б. Олон улсын 3-аас доошгүй төсөл хөтөлбөрт ажиллаж байсан туршлагатай байх;
- в. Компьютерын өргөн хэрэглээний болон санхүүгийн программыг бүрэн эзэмшсэн байх
- г. Багаар ажиллах чадвартай байх.

ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН АЖИЛТАНД  
ТАВИГДАХ ШААРДЛАГА:

А. Ерөнхий шаардлага:

- а. Нягтлан бодох, санхүүгийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй байх;
- б. Мэргэшсэн нягтлан бодогч байх;

В. Ажлын туршлага:

- а. Мэргэжлээрээ 10-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- б. Монгол хэл бичгийн албан хэрэг хөтлөх ур чадвартай байх.

С. Бусад

- а. Англи хэлний аман болон бичгийн түвшинд чөлөөтэй эзэмшсэн байх шаардлагатай;
- б. Олон улсын төсөл хөтөлбөрт ажиллаж байсан туршлагатай байх;
- в. Компьютерын өргөн хэрэглээний болон санхүүгийн программыг бүрэн эзэмшсэн байх
- г. Багаар ажиллах чадвартай байх.

ТӨСЛИЙН ЖОЛООЧИД  
ТАВИГДАХ ШААРДЛАГА:

А. Ерөнхий шаардлага:

- а. Дунд ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
- б. Мэргэшсэн жолооч байвал давуу тал болно.

В. Ажлын туршлага:

- а. Мэргэжлээрээ 10-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- б. Багаар ажиллах, бартаат зам, орон нутгийн замын туршлагатай байх,
- в. Машин, техникийн арчилгаа, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах талаар туршлага, чадвартай байх.

С. Бусад

- а. Олон улсын төсөл хөтөлбөрт ажиллаж байсан туршлагатай байх;
- б. Хорт зуршилгүй, механик араатай машин жолоодох туршлагатай байх;
- в. Оффисын болон бусад дагалдах ажлуудыг гүйцэтгэх чадвартай байх (ачаа зөөх, архивын бичиг баримт үдэх, цэгцлэх гэх мэт).